

# Бурханы Авралын Энгийн Төлөвлөгөө

**Эрхэм Анд минь**, Би чамаас амийн тухай маш чухал асуулт асууя. **Та мөнхөд баяр жаргалтай байх уу эсвэл харуусал гунигтай байх уу гэдэг таны хариултаас хамаарна.** Энэ асуулт бол **Та аврагдсан уу?** Энэ бол таныг хэр сайн хүн бэ эсвэл та аль нэг сүм чуулганы гишүүн үү гэж биш харин **та аврагдсан уу?** гэсэн асуулт юм. **Таныг нас барахад сүнс тань Мөнхийн улсад орно гэдэгт итгэлтэй байна уу?**

Бурхан хэлэхдээ хүн Мөнхийн улсад орохын тулд дахин төрөх ёстой гэж хэлсэн. Иохан 3:7 д Эсүс Некодемд, **“Та дахин төрөх ёстой”** гэж хэлсэн.

Библид хүн аврагдахын тулд хэрхэн дахин төрөх тухай зааврыг Бурхан өгсөн. Түүний авралын төлөвлөгөө бол энгийн! Та өнөөдөр ч аврагдаж болно. Яаж гэж үү?

Эхлээд та гэмтэй гэдгээ мэдэх нь чухал. **“Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй”** (Ром 3:23)

Та гэмтэй учраас **үхлийн шийтгэл дор байна.** **“Учир нь нүглийн хөлс [шийтгэл] нь үхэл”** (Ром 6:23) Энэ бол мөнхөд Бурханаас тусгаарлагдан Тамд орхигдох шийтгэл юм.

**“Хүн ганц удаа үхэж, дараа нь шүүгдэхээр товлогдсон...”** (Еврей 9:27).

Харин Бурхан танд маш их хайртай учир **Өөрийн цорын ганц хүү Эсүсээ гэмийн тань шийтгэлийн золиос болгон үхлийн шийтгэлийг Түүнд үүрүүлсэн.** **“Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосоны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм** (2 Коринт 5:21).

**Эсүс цусаа урсган үхэх ёстой болсон.** **“Учир нь бие махбодын амь нь цусад байдаг”** (Леви 17:11). **“... цус урсахгүйгээр уучлал үгүй ажээ”** (Еврей 9:22).

**“...биднийг нүгэлтнүүд байхын л Христ бидний төлөө үхснээр Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан”** (Ром 5:8).

Хэдийгээр бид үүнийг ойлгохгүй байгаа ч Бурхан хэлэхдээ **миний болон таны гэм Эсүст тохогдож Тэр бидний өмнөөс нас барсан.** Тэр бидний гэмийн золиос болсон. Энэ бол үнэн. Бурхан худал ярьдаггүй.

Анд минь, **“... эдүгээ хаа сайгүй хүн бүхэн гэмших ёстойг хүмүүст Тэрээр тушааж байна”** (Үйлс 17:30). Энэ гэмшил бол Бурхантай нэгдэж гэм нүгэлтэй оюун санаагаа өөрчлөн Эсүс бидний төлөө загалмайд цовдлогдсоныг хүлээн зөвшөөрөх юм.

Үйлс 16:30-31, Шоронгийн хуяг Паул, Силас хоёроос: **“... Ноёд оо, аврагдахын тулд би юу хийх ёстой вэ? гэв. “...Эзэн Эсүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдах болно”** гэлээ.

Гэмийн тань шийтгэлийг **үүрч, таны өмнөөс нас барж** оршуулагдсан ч Эзэн Бурханаар амилуулагдсан Нэгэнд итгээрэй. Тэр үхлээс амилсанаар **өөрт нь итгэж Эсүсийг Аврагчаар хүлээн авсан хүн бүрт мөнх амийг баталгаа болгон өгдөг.**

**“Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө”** (Иохан 1:12).

Учир нь **“Эзэний нэрийг дууддаг бүхэн аврагдах болно”** (Ром 10:13).

**Бүхэн** гэдэгт та багтаж байна. **Аврагдах болно** энэ үг магад эсвэл болох юм гэсэн утга агуулаагүй, **харин аврагдах болно.**

Та яг одоо гэмтэйгээ ухааран хаа байгаа газраа гэмшин залбирч зүрх сэтгэлээ Бурханд өргөөрэй.

Лук 18:13, **“Бурхан минь нүгэлт намайг өршөөгөөч”** гэж нэгэн гэмтэн залбирсан. *Та залбирахдаа “Өө Бурхан, би өөрийгөө гэмтэй гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Есүс миний өмнөөс Загалмай дээр нас барсан гэдэгт итгэж байна. Түүний цусаа урсгасан нь, үхээд оршуулагдсан нь, мөн үхлээс амилсан нь миний тусын тулд юм гэдэгт итгэж байна. Одоо би Түүнийг аврагчаараа хүлээн авч байна. Та Өөрийнхөө нигүүлслээр миний гэм нүглийг өршөөж, авралын бэлэг болон мөнх амийг өгсөнд баярлалаа. Амен”*

**Бурханы хэлсэн үгийн дагуу итгэлээр Түүний авралыг аваарай. Итгээрэй тэгвэл аврагдана. Сүм ч, буяны ба сайн үйлс ч таныг аврахгүй. Хүнийг авардаг нь зөвхөн Бурхан гэдгийг сана!**

**Бурханы авралын энгийн төлөвлөгөө бол: Та гэмтэн.** Тиймээс, Таны оронд үхэх ялыг тань авсан Есүст итгэхгүй бол өөрөө шийтгэлээ мөнхөд тамд эдлэнэ. Хэрэв таны төлөө цовдлогдон нас барж оршуулагдаад амилсан Аврагч Есүст итгэвэл таны хийсэн бүх гэм уучлагдан **итгэлээр мөнх амийн бэлгийг** хүлээн авна.

“Ингээд л болно гэж үү” гэж гайхаж байна уу? Тийм ээ! Энэ нь судрын дагуу юм. Энэ бол Бурханы төлөвлөгөө. **Анд минь, Есүст итгэн өнөөдөр Түүнийг Аврагчаараа хүлээж аваарай.**

Хэрэв Түүний төлөвлөгөөг хараахан ойлгохгүй байгаа бол **энэ товхимолыг орхилгүйгээр ойлгох хүртлээ дахин дахин уншаарай.** Сүнс тань бүх дэлхийгээс ч илүү үнэ цэнэтэй.

**“Учир нь хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ?”** (Марк8:36).

Баттай аврагдаарай. Хэрэв сүнсээ алдвал, Мөнхийн улсыг бас бүхнийг алдана. Гуйж байна! **Яг энэ мөчид Бурханаас авралыг аваарай.**

**Бурханы хүч таныг авраад батлан хамгаалж** ялгуулсан Христич амьдралаар амьдрах боломжтой болно. **“Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл. Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын тань тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно”** (1 Коринт 10:13).

**Өөрийнхөө мэдрэмжид бүү итгэ. Энэ нь өөрчлөгдөж байдаг. Бурханы амлалтууд дээр бат зогс. Эдгээр нь хэзээ ч өөрчлөгддөггүй.** Та аврагдсаныхаа дараа сүнсний өсөлтдөө анхаарч гурван зүйлийг өдөр тутмын хэвшил болгон хийгээрэй.

**Залбир- Ингэж та Бурхантай ярина.**

**Библиэ унш - Бурхан тантай ярина.**

**Гэрчил - Бусадтай Бурханы тухай хуваалц**

Эзэн Есүс Христийг дуулгавартай дагаж **аврагдсанаа бусдад гэрчлэн харуулж** баптисм хүртэж Библид итгэгч чуулганд хойшлуулалгүй нэгдэх хэрэгтэй. **“Тиймээс бидний Эзэний гэрчлэлээс ч бүү ич...”**(2 Тимот 1:8).

**“Тиймээс хүмүүсимйн өмнө Намайг хүлээн зөвшөөрөгч хүн бүрийг Би тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө мөн хүлээн зөвшөөрнө”** (Матай 10:32).